

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 05 дугаар
сарын 30 -ны өдөр

Дугаар А/148. А/33

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам"-ыг нэгдүгээр, "Химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй бодис, бүтээгдэхүүний жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Цэнгэл/, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Даваасүрэн/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/-д даалгасугай.

4. Тушаал батлагдсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Гадаад харилцааны сайдын 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 334/104 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Д.ОЮУНХОРОЛ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Ц. МӨНХ-ОРГИЛ



Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 8-9, 11, 15 болон 18 дугаар зүйлд заасан химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдахтай холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөл /цаашид "зөвшөөрөл" гэх/ олгох, тэдгээрт тавих шаардлага болон экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагааны эрх зүйн хэм хэмжээг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.3. Озон задалдаг бодисыг импортлох, худалдах, ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг Засгийн газрын "Озон задалдаг бодисыг импортлох, ашиглах зөвшөөрөл олгох журам"-аар зохицуулна.

1.4. Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, худалдаа эрхлэхтэй холбогдсон үйл ажиллагааг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, холбогдох журмаар зохицуулна.

1.5. Эмийн бодис, цацраг идэвхит бодис, хүнсний зориулалттай бодис, тэсэрч дэлбэрэх бодистой холбогдсон харилцааг тусгай хууль, тэдгээрийг дагаж гарсан журмаар зохицуулна.

1.6. Биологийн, бактерийн гаралтай бэлдмэл, био бордоо, тэжээлт орчин зэрэг бүтээгдэхүүн энэ журмаар зохицуулагдахгүй.

Хоёр. Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөл олгох

2.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг үндэслэн дараахь зөвшөөрлийг олгоно:

2.1.1. Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах;

2.2. Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах

Зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

2.2.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь албан бичгээр хүсэлт гаргах бөгөөд зөвшөөрөл хүссэн бодисын олон улсын болон монгол нэршил, худалдааны нэр, зориулалт, химийн томъёо, олон улсын бүртгэлийн дугаар (CAS number), зөвшөөрөл хүссэн тоо хэмжээ, улсын хилээр нэвтрүүлэх боомт, химийн бодис хадгалах, ашиглах үйл ажиллагаа явуулах байршил, хаяг, зөвшөөрлийн төрөл зэргийг тодорхой тусгасан байх;

2.2.2. Аж ахуйн нэгжийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний, иргэний хувьд иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар¹;

2.2.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажсан, химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээ бүхий "Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн эх хувь";

2.2.4. Химийн бодисын нийлүүлэгч тал болон худалдан авагч талуудын хооронд байгуулсан гэрээний хуулбар, түүний монгол хэл дээрх албан ёсны орчуулгыг хавсаргасан байна;

2.2.5. Үйлдвэрлэгч, эсхүл албан ёсны борлуулагчаас тухайн химийн бодисыг дагалдуулан өгсөн хор, аюулын лавлах мэдээлэл, түүний монгол хэлээрх албан ёсны орчуулгыг хавсаргасан байна;

2.2.6. Тухайн химийн бодисуудын дагалдах гэрчилгээ (англи, монгол, орос аль нэг хэлээр);

2.2.7. Химийн пестицид, ахуйн хортон шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, тэсэрч дэлбэрэх бодисын түүхий эд, химийн бодис экспортлох, импортлох, үйлдвэрлэх, худалдах тохиолдолд холбогдох төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар;

2.2.8. Урьд нь зөвшөөрөл авсан химийн бодисын ашиглалт, зарцуулалт, үлдэгдэл болон тэдгээр химийн бодисын сав баглаа, боодлын тайлан;

2.2.9. Судалгаа шинжилгээний хүрээлэн, хяналт шинжилгээний лаборатори, их, дээд, дунд сургууль, эмийн сан, эмнэлэг нь химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалтын дагуу гаргасан дүгнэлт;

¹ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль

Дээр дурдсанаас бусад химийн бодис импортлох, ашиглах, үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014" стандартын шаардлагын дагуу гаргасан мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;

2.2.10. Зөвхөн шинжилгээ, судалгааны зориулалтаар ашиглагдах "Монгол улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт"-д орсон стандарт уусмал бодис болон "Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт"-д орсон химийн бодисыг ашиглах, мөн химийн бодис үйлдвэрлэх бол Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн шинжээчдийн багийн дүгнэлт;

2.3. Экспортлох зөвшөөрөл олгоход тавигдах нэмэлт шаардлага

Химийн хорт болон аюултай бодис экспортлох зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ журмын 2.2-т зааснаас гадна дараахь материалыг нэмж бүрдүүлсэн байна:

2.3.1. Тухайн бодисыг олон улсын хэмжээнд болон хоёр талын хооронд худалдаалах, хил дамжуулан тээвэрлэх олон улсын гэрээний шаардлагыг хангасан тухай танилцуулга;

2.3.2. Нийлүүлэгч, хүлээн авагч, тээвэрлэгч талын хооронд хийсэн гэрээний хуулбар, түүний монгол хэлээрх албан ёсны орчуулга болон бусад шаардлагатай баримт бичиг;

2.3.3. Урьд нь авсан зөвшөөрлийн дагуу химийн хорт болон аюултай бодис хил дамжуулан тээвэрлэсэн тухай тайлан.

2.4. Импортлох зөвшөөрөл олгоход тавигдах нэмэлт шаардлага.

2.4.1. Химийн хорт болон аюултай бодис импортлох зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад химийн хорт болон аюултай бодис импортлох зөвшөөрлийг дангаар нь олгохгүй бөгөөд үйл ажиллагааных нь дагуу ашиглах болон худалдах зөвшөөрлийн аль нэгтэй, эсхүл хамтад нь олгоно.

2.4.2. Шаардлагатай тохиолдолд химийн хорт болон аюултай бодисыг Гаалийн төв лабораторийн шинжилгээнд хамруулж, "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн дагуу ангиллын код тодорхойлуулна.

2.5. Хил дамжуулан тээвэрлэх зөвшөөрөл олгоход тавигдах нэмэлт шаардлага

2.5.1. Химийн хорт болон аюултай бодис хил дамжуулан тээвэрлэх зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 2.2.1, 2.2.2, 2.2.5, 2.2.6, 2.2.8, 2.2.10-т заасан материалаас гадна нийлүүлэгч-хүлээн авагч этгээдийн хооронд, эсхүл нийлүүлэгч-дамжин өнгөрүүлэгч, хүлээн авагч-дамжин өнгөрүүлэгчийн хооронд байгуулсан гэрээний хуулбар болон түүний монгол, англи хэлээрх албан ёсны орчуулгыг хавсаргана.

2.6. Үйлдвэрлэх зөвшөөрөл олгоход тавигдах нэмэлт шаардлага

Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 2.2-т зааснаас гадна дараахь материалыг нэмж бүрдүүлсэн байна:

2.6.1. Үйлдвэрлэл эрхлэхийг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, хүлээн авсан улсын комиссын акт, дүгнэлтийн хуулбар;

2.6.2. Үйлдвэрлэх химийн бодисын хор, аюулын лавлах мэдээллийг боловсруулж, Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлөөр дүгнэлт гаргуулсан байна.

2.7. Худалдах зөвшөөрөл олгоход тавигдах нэмэлт шаардлага

2.7.1 Химийн хорт болон аюултай бодис худалдах зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн эзэмшлийн, эсхүл бусад этгээдээс түрээсээр эзэмшдэг химийн бодисын агуулахдаа энэ журмын 2.2.3-д заасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг заавал хийлгэсэн байна.

2.7.2 Химийн хорт болон аюултай бодис худалдах зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ журмын 2.2-т заасан материалыг бүрдүүлэхээс гадна нийлүүлэгч талтай байгуулсан гэрээний хуулбарыг хавсаргасан байна.

Гурав. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагад тавигдах шаардлага

3.1. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага дараахь шаардлагыг биелүүлнэ. Үүнд:

3.1.1. Химийн хорт ба аюултай бодис нь зориулалтын сав, баглаа боодол, стандартын шаардлага хангасан англи, орос, монгол хэлээр үйлдэгдсэн хаяг, шошготой байна.

3.1.2. Химийн хорт ба аюултай бодисыг анхааруулах тэмдэг бүхий зориулалтын тээврийн хэрэгслээр, орон нутгийн Онцгой байдлын газар болон

Цагдаагийн газраар батлуулсан маршрутын дагуу тээвэрлэх бөгөөд тээвэрлэх, ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагааг химийн бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, худалдах үйл ажиллагаа эрхлэгч хариуцна.

3.1.3. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч нь тээвэрлэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа тухайн бодисын хор, аюулгүй байдлын монгол хэлээрх лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилга, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулсан байна.

3.1.4. Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч нь энэ талаар гарсан олон улсын гэрээний шаардлагыг биелүүлэх үүрэгтэй бөгөөд тээвэрлэлт, ачилт, буулгалтын үед гарч болох осол, эрсдлээс урьдчилан сэргийлэх, осол гэмтэл гарсан тохиолдолд хор, аюулыг бууруулах арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлсэн байна.

3.1.5. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь химийн хорт болон аюултай бодисыг импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэхээс өмнө тухайн химийн бодисыг нэвтрүүлэх боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

3.1.6. Иргэн аж ахуйн нэгж, байгууллага нь химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэхдээ тусгай зөвшөөрөл, экспортлогч талын эрх бүхий байгууллагаас олгосон чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтын баримт бичиг, үйлдвэрлэгчийн боловсруулсан хор аюулын лавлах мэдээллийн хуудас, тээврийн гэрээ, худалдааны гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичгийг бүрдүүлсэн байна.

3.1.7. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь химийн чиглэлээр мэргэшсэн ажилтантай байна.

3.1.8. Химийн хорт болон аюултай бодисыг ачиж буулгах, нэг тээврийн хэрэгслээс нөгөө тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачих үйл ажиллагааг улсын байцаагчийн хяналт дор шаардлага хангасан зориулалтын талбайд явуулна.

3.1.9. Зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь экспортолсон, импортолсон, хил дамжуулан тээвэрлэсэн, үйлдвэрлэсэн, худалдсан химийн хорт болон аюултай бодис бүрээр нийлүүлэлт, зарцуулалтын хөдөлгөөний тухайн жилийн тайлан, мөн тухайн химийн хорт болон аюултай бодисуудын сав баглаа боодлын тайланг тус тус гаргаж, дараа жилийн 01 дүгээр сарын 25-ны дотор Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.1.10. Химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллага нь тухайн жилийн эцэст ашигласан химийн бодисынхоо

сав баглаа, боодлыг зохих зөвшөөрөлтэй, зориулалтын устгах байгууламжтай аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэн өгч, устгуулах үүрэг хүлээнэ.

3.1.11. Тухайн жилд химийн хорт болон аюултай бодис болон түүний сав баглаа, боодлын нийлүүлэлт, зарцуулалтын тайланг ирүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагад дахин химийн бодисын тусгай зөвшөөрөл олгохгүй байж болох бөгөөд энэ нь өмнө олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болно.

3.2. Химийн хорт болон аюултай бодисыг үйлдвэрлэгчид тавих шаардлага

Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 3.1-т зааснаас гадна дараахь шаардлагыг биелүүлнэ:

3.2.1. Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэгч нь хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байранд, технологийн горимыг нарийн чанд баримтлан ажиллана.

3.2.2. Үйлдвэрлэгч нь орчиндоо болон ажлын байранд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн бодис бүхий хорт хий, хог хаягдал, тоос, тоосонцор гаргахгүй байх үүрэг хүлээх ба гаргасан тохиолдолд түүнийг бууруулах, саармагжуулах, байгаль орчинд халгүй аргаар устгах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

3.2.3. Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүнээ борлуулахдаа тухайн бодисын хор, аюулгүй байдлын лавлах мэдээллийг заавал дагалдуулан өгнө.

3.3. Химийн хорт болон аюултай бодисыг худалдахад тавих шаардлага

Химийн хорт болон аюултай бодис худалдах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 3.1-т зааснаас гадна дараахь шаардлагыг биелүүлнэ:

3.3.1. Химийн хорт болон аюултай бодис ашиглах зөвшөөрөлгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад химийн хорт болон аюултай бодисыг худалдахыг хориглоно.

3.3.2. Химийн хорт болон аюултай бодисыг худалдахдаа худалдан авсан этгээдийн нэр, хаяг, бодисын нэр төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан баримтыг 2 хувь үйлдэн баталгаажуулж, нэг хувийг худалдан авагчид, үлдсэн хувийг өөртөө хадгална.

3.3.3. Химийн хорт болон аюултай бодисыг худалдахдаа худалдан авагчид тухайн бодисын хор, аюулгүй ажиллагааны лавлах мэдээллийг монгол хэлээр орчуулж, заавал дагалдуулан өгнө.

3.3.4. Химийн хорт болон аюултай бодисыг жижиглэнгээр худалдахдаа зориулалтын, битүүмжлэлтэй, хаяг шошго бүхий саванд савласан байна.

3.3.5. Химийн хорт болон аюултай бодис худалдсан аж ахуй нэгж, байгууллага нь худалдан авагч байгууллагаас химийн бодисын сав баглаа, боодлыг хүлээлгэн өгсөн тоо хэмжээнийхээ дагуу тухайн оны эцэст цуглуулан авч, зохих зөвшөөрөлтэй, зориулалтын, устгах байгууллагад хүлээлгэн өгөх үүрэг хүлээнэ.

Дөрөв. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох,
хил дамжуулан тээвэрлэх үеийн мэргэжлийн
хяналтын байгууллагын хяналт шалгалт

4.1. Хилийн мэргэжлийн хяналтын байгууллага экспорт, импорт болон хил дамжуулан тээвэрлэж буй химийн хорт болон аюултай бодисын хяналт шалгалтыг хийж, дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1. Экспортолж, импортолж байгаа болон хил дамжуулан тээвэрлэж буй химийн хорт болон аюултай бодис нь бичиг баримтын зөрчилгүй нөхцөлд биет үзлэг, шалгалтыг хийнэ.

4.1.2. Биет үзлэг, шалгалтаар зөрчил илрээгүй болон лабораторийн шинжилгээнд хамруулах шаардлагагүй тохиолдолд улсын байцаагч нь химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүнийг хилийн мэргэжлийн хяналт шалгалтаас чөлөөлж, мэдэгдлийг иргэн, хуулийн этгээдэд өгнө.

4.1.3. Баримт бичгийн болон биет үзлэг, шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүнийг 72 цаг хүртэл хугацаагаар түр саатуулах, эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авна. Энэ тухай мэдэгдлийг улсын байцаагч хариуцагч иргэн, хуулийн этгээдэд хүргүүлнэ.

4.1.4. Түр саатуулах хугацаанд зөрчил арилаагүй тохиолдолд химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүнийг хариуцагч иргэн, хуулийн этгээдийн өөрсдийнх нь зардлаар экспортлогч улсад буцаах, эсвэл химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 19.1.9-д заасны дагуу улсын орлого болгон хурааж авна.

Тав. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох,
хил дамжуулан тээвэрлэх үеийн гаалийн хяналт шалгалт

5.1. Гаалийн байгууллага нь экспорт, импорт болон хил дамжуулан тээвэрлэж буй химийн хорт болон аюултай бодисын хяналт шалгалтыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ.

5.1.1. Хилийн мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон дүгнэлтийг үндэслэн гаалийн хяналт шалгалт хийнэ. Шаардлагатай тохиолдолд химийн бодисоос дээж авна.

5.1.2. Баримт бичиг болон бусад шалгалтаар зөрчил илрээгүй тохиолдолд гаалийн бүрдүүлэлт хийж, улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

5.1.2. Баримт бичиг болон бусад шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд гаалийн болон холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Бусад зүйл


6.1. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдахтай холбогдсон журам зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтыг үндэслэн Байгаль орчны болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталдаг "химийн хорт болон аюултай бодисын ангилал" нь химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл олгох болон олгохгүй байх үндэслэл болохгүй.

6.3. Химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй бодис, бүтээгдэхүүний жагсаалтад шууд хэрэглэх зориулалтгүй, өндөр концентрацитай, их хэмжээгээр савласан, жижиглэн савлаж хаяг шошгожуулан борлуулах, мөн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалттай химийн гаралтай түүхий эд, химийн бүтээгдэхүүнүүд хамаарахгүй.

6.4. Энэхүү журам нь Байгаль орчин болон Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар батлагдан, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, улсын нэгдсэн бүртгэлийн дугаар авсны дараа хүчин төгөлдөр үйлчилнэ.

___оОо___



Химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулах тээвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл авах шаардлагатгүй химийн бодис, бүтээгдэхүүний жагсаалт

Д/д	Зориулалт	Нэр	БТКУС ¹ код	Савлагаа, тавигдах шаардлага	Нийт хэмжээ, кг
1	Судалгаа шинжилгээнд ашиглах /Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байх/	1 кг эсвэл 1 л болон түүнээс багаар савласан бодис, урвалжууд,	28, 29 дүгээр бүлэг	1 кг эсвэл 1 л болон түүнээс бага савалгаатай, ("Монгол улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт"-д ороогүй байх), зөвхөн энэ мөрөнд заагдсан бодис, урвалжуудыг Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдах тохиолдолд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагатай болно.	10 кг-аас ихгүй байх
2	Судалгаа шинжилгээнд ашиглах /Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байх /	Стандарт бодисууд (фиксонал)	38.22	Тодорхой концентрацитай, 0.5кг эсвэл 0.5л болон түүнээс бага ампультай савалгаатай, ("Монгол улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт"-д ороогүй байх)	5кг-аас ихгүй байх
3	Судалгаа, хяналт шинжилгээнд ашиглах /Холбогдох байгууллагаас зөвшөөрөлтэй байх/	Тэжээлт орчин	38.22	Хорио цээрийн шаардлага хангасан сав баглаа боодолтой	Хэмжээ хамаарахгүй
4	Ахуйн болон гоо сайхны зориулалттай /Олон улсын стандартын шаардлагыг хангасан гэрчилгээтэй байх/	Төрөл бүрийн угаалга, цэвэрлэгээний бодис, шингэнүүд	34-р бүлэг	Жижиглэн борлуулах зориулалтаар 10кг эсвэл 10л түүнээс бага савалгаатай, (Хэрэглэх заавар нь шошго дээрээ тодорхой байх)	Хэмжээ хамаарахгүй
		Гоо сайхны бүтээгдэхүүнүүд	33-р бүлэг	Жижиглэн борлуулах зориулалтаар савлагдсан байх	Хэмжээ хамаарахгүй

5	Хүнсний болон үйлдвэрийн зориулалттай	Желатин	35.03	Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, холбогдох тогтоомжинд заасан шаардлагыг хангасан байх	Хэмжээ хамаарахгүй	
		Декстрин	17.02			
		Ундааны нүүрсхүчлийн хий	28.11			
		Эрдсийн гаралтай чийг татагч	38.24			
6	Зөвхөн барилгын материалын зориулалтаар хэрэглэгдэх, үйлдвэрлэлд ашиглагдах	Лак, будаг, эмульс	32-р бүлэг	Барилгын тухай хуулийн 13-р зүйлд заасан шаардлагыг хангасан байх, барааны аюулгүй ажиллагааны заавар (MSDS)-тай бүтээгдэхүүн байх,	Хэмжээ хамаарахгүй	
		Чигжээс, шаваас	32.14			
		Цавуу	35.05 35.06			
		Дулаалгын хөөсөнцөр үйлдвэрлэх зориулалттай полимер түүхий эд	39.01			
		Шуудай үйлдвэрлэх зориулалттай полимер түүхий эд	39.02 39.03 39.04			
		Шугам хоолой үйлдвэрлэх зориулалттай полимер түүхий эд				
7	Барилга, уул уурхай, үйлдвэрлэл, бусад хэрэглээнд	Гипс	25-р бүлэг	Барилгын тухай хуулийн 13-р зүйлд заасан шаардлагыг хангасан байх, Савлагаа хамаарахгүй, барааны аюулгүй ажиллагааны заавар (MSDS)-тай бүтээгдэхүүн байх,	Хэмжээ хамаарахгүй	
		Каолин шавар				
		Бентонит				
		Цеолит				
		Графит				
		Кварц				
		Түүхий шохой				
		Боловсруулсан болон боловсруулаагүй эрдэс бүтээгдэхүүн				
		Төмрийн хайлш				72.02
		Идэвхижүүлсэн нүүрс				38.02
Силикагель	69.01					
8	Хэвлэлд ашиглах /Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байх/	Хэвлэлийн хор	37-р бүлэг	Үйлдвэрлэгчийн савалгаатай, чанарын гэрчилгээтэй, барааны аюулгүй ажиллагааны заавар (MSDS)-тай бүтээгдэхүүн байх	Хэмжээ хамаарахгүй	
		Фото зургийн хор				
		Хэвлэлийн будаг				
9	Зам болон тээврийн хэрэгслэлд ашиглах	Тос, тосолгооны материал	27-р бүлэг	Савлагаа хамаарахгүй, Олон улсын стандартын шаардлага хангасан гэрчилгээтэй, барааны аюулгүй ажиллагааны заавар (MSDS)-тай бүтээгдэхүүн байх	Хэмжээ хамаарахгүй	
		Антифриз				
		Тосол				
		Асфальт				
		Битум				
Парафин						
10	Ахуйн зориулалттай	Асаагуурын шахсан хий	-	Жижиглэн борлуулах зориулалттай, савалгаатай	Хэмжээ хамаарахгүй	

11	Тоног төхөөрөмж дагалдаж ирсэн бодис урвалж	Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг шалгах тохируулгын бодис урвалж	Хамтад нь кодлогдсон	Тухайн тоног төхөөрөмжтэйгөө хамтад нь нийлүүлэгдсэн ("Монгол улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт"-д ороогүй байх	20 кг-аас ихгүй байх
12	Ахуйн болон бусад зориулалттай	Төрөл бүрийн савалгаатай галын хор	-	Монгол улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодис, озон задлагч бодисын жагсаалтанд орсон бодис агуулаагүй байх, чанарын гэрчилгээтэй, барааны аюулгүй ажиллагааны заавар (MSDS)-тэй бүтээгдэхүүн байх	Хэмжээ хамаарахгүй
13	Хүнсний зориулалттай	Хуванцар уут савны түүхий эд	39.01 39.02 39.07	Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, холбогдох тогтоомжинд заасан шаардлагыг хангасан байх	Хэмжээ хамаарахгүй

¹/БТКУСИ - "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"